



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/406

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын “Коронавируст халдвар Ковид-19-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г нэгдүгээр, хүч хэрэгслийн тооцоог (нууц) хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00003070

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН
КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХАЛТАЙ
ТЭМЦЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 он

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
А/306 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Коронавируст халдвар “Ковид-19”-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэр, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалын хэрэгжилтийг шуурхай хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах тухай хууль, Онц байдлын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2015 оны 491 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл үүссэн үед” харилцан ажиллагааг зохицуулах онцгой байдлын байгууллагын чиглэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулав.

1.2. Хамрах хүрээ

1.2.1. Тус төлөвлөгөө нь цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах удирдлагын баримт бичиг болно.

1.2.2. Төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, нэгжийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрэгжүүлнэ.

1.3. Нэр томьёо, товчилсон үг

1.3.1. Энэхүү төлөвлөгөөнд ашигласан нэр томьёог Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрэм, стандартад тодорхойлсноор ойлгоно.

1.3.2 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд туссан товчилсон үгийг дор дурдсанаар ойлгоно.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Коронавируст халдвар “Ковид-19”-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэр, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалын хэрэгжилтийг шуурхай хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах тухай хууль, Онц байдлын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2015 оны 491 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл үүссэн үед” харилцан ажиллагааг зохицуулах онцгой байдлын байгууллагын чиглэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулав.

1.2. Хамрах хүрээ

1.2.1. Тус төлөвлөгөө нь цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах удирдлагын баримт бичиг болно.

1.2.2. Төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, нэгжийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрэгжүүлнэ.

1.3. Нэр томъёо, товчилсон үг

1.3.1. Энэхүү төлөвлөгөөнд ашигласан нэр томъёог Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, журам, дүрэм, стандартад тодорхойлсноор ойлгоно.

1.3.2 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд туссан товчилсон үгийг дор дурдсанаар ойлгоно.


ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

АНОК	Аймаг, нийслэлийн онцгой комисс
АОБГ	аймгийн Онцгой байдлын газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
ГХУА	Гамшгаас хамгаалах улсын албад
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
СЯ	Сангийн яам
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТЦБ	Төрийн цэргийн байгууллага
ТЦА	Тээврийн цагдаагийн алба
УОК	Улсын онцгой комисс
УОКШШ	Улсын онцгой комиссын Шуурхай штаб
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХЗХ	Харилцаа, холбооны зохицуулах хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ХОЁР. ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Цар тахлын үеийн удирдлагыг улсын хэмжээнд дараахь байдлаар зохион байгуулна.

Бүдүүвч 1. Удирдлагын зохион байгуулалт




- Шийдвэр гаргах,
- Шийдвэрт хяналт тавих,
- Мэргэжлийн арга зүй, бодлогын зөвлөмж өгөх,
- - - Шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах,

2.2. Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг уялдуулан зохицуулах, шуурхай зохион байгуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах үйл ажиллагааг аймаг, орон нутгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаснаар зохион байгуулна.

2.3. Цар тахлын нөхцөл байдал, хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг Улсын болон орон нутгийн онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын хооронд шуурхай солилцох, олон нийтийг үнэн зөв, мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагааг дараахь байдлаар зохион байгуулна:

Бүдүүвч 2. Онцгой байдлын албаны хэмжээнд мэдээ, мэдээлэл солилцох схем



ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх үеийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь алба хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг ойлголт өгөх, холбогдох байгууллагын ажилтан албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн хамтран ажиллах, бэлэн байдлыг хангах, Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэр, мэргэжлийн байгууллага, засаг захиргааны нэгжээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг ажилтан алба хаагчдад шуурхай хүргэх, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангахад чиглэнэ.

3.2. Цар тахалтай тэмцэх үеийн мэдээ, мэдээлэл, урьдчилан сэргийлэх сурталчилгааг аймаг, нийслэлийн хэмжээнд бүх төрлийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн

цахим сүлжээ, үүрэн телефоны оператор, харилцаа холбооны сүлжээг ашиглан иргэд, олон нийтэд ил тод, шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэнэ.

ДӨРӨВ. НӨӨЦ, ХАНГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Цар тахлын үеийн хангалтыг дараахь байдлаар зохион байгуулах бөгөөд нөөц, хангалтыг нэн тэргүүнд бүрдүүлнэ:

Нөөц, хангалтын төрөл, бүрдүүлэлт		Хэрэгжүүлэх бүтцийн нэгж
1	Холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдал, хангалт	ГШУГ, (ХЗМХ, ШУЗМТ)
2	Алба хаагчдын эрүүл мэнд, дархлааг дэмжих эм, ариутгал хийх бодис материалын нөөц, хангалт	ГШУГ, (СХХОГ, УНХТГ)
3	Ус, хүнсний хангамж, бэлэн байдал	СХХОГ, (УНХТГ, ТССЗТ)
4	Алба хаагчдын ажлын байрны хүрэлцээ, бэлэн байдал <i>/халдварын үед нэг өрөөнд байрлах хүний тоо, зай хэмжээ төлөвлөх/</i>	ЗУГ
5	Шуурхай ажлын хэсгийн тээврийн хэрэгслийн бэлэн байдал	ҮАБ
6	Шатах, тослох материалын бэлэн байдал, нөөц, хангалт	СХХОГ, (ҮАБ)

ТАВ. ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮЧ ХЭРЭГСЭЛ.

5.1. Цар тахлын үед гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг анги, салбар бүрээр тодотгол хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагын хүч хэрэгслийг татан оролцуулж хамтран ажиллах.

5.2. Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, орон нутагт тухайн аймгийн Онцгой байдлын газар, хэлтсээс мэргэжлийн удирдлагаар хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах бөгөөд шаардлагатай бол Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар баталсан “Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам”-ын 4.2 дахь хэсэгт заасны дагуу шуурхай бүлэг, ажлын хэсгийг томилон үүрэг гүйцэтгүүлнэ.

ЗУРГАА. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

6.1. Цар тахлын үед иргэн, байгууллага, аж ахуй нэгжээс үзүүлж буй хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын дагуу зохион байгуулна.

6.2. Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авахдаа “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.4 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна. Үүнд:

Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх бүтцийн нэгж	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Хүлээн авах	ОБЕГ	УНХТГ	АНОБГ
Тээвэрлэх	ОБЕГ	УНХТГ	ҮАБ,
Хадгалах	ОБЕГ	УНХТГ	Бусад
Хуваарилах	ОБЕГ	УНХТГ (СХХОГ)	АНОБГ
Олгох	ОБЕГ	УНХТГ (СХХОГ)	АНОБГ
Хяналт тавих	ОБЕГ		АНОК, АНОБГ

6.3. Онцгой байдлын байгууллагад нэр заан ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн бараа, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан агуулахад технологийн дагуу хадгална.

6.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын тайлан, мэдээг журамд заасны дагуу тайлагнаж, хяналт үнэлгээ хийлгэж болно.

ДОЛОО. ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

7.1. Хүн амын дундах цар тахлын өвчлөлийн тархалтыг “Шар”, “Улбар шар”, “Улаан” түвшингээр ангилж, хариу арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль, Онц байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах байдлаар төлөвлөнө.

7.2. Онцгой байдлын ерөнхий газрын хэмжээнд “Шар” болон “Улбар шар” тохиолдлын хүрээнд цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

Түвшин	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг	Цар тахлын өвчлөл	Тодорхойлолт
Шар	Өндөржүүлсэн бэлэн байдал	Алаг цоог өвчлөл	Цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоогүй тохиолдол бүртгэгдсэн.
Улбар шар	Бүх нийтийн бэлэн байдал	Кластер өвчлөл	Цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоотой хязгаарлагдмал хүрээнд тохиолдол бүртгэсэн.
Улаан	Онц байдал	Нийт хүн мын өвчлөл	Нийт хүн амын дунд тархсан.

7.3. Цар тахлын өвчлөлийн тархалт “Улаан түвшин”-д хүрч “Онц байдал” зарласан тохиолдолд хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний хүрээнд тусгайлан боловсруулж батлуулна.

**7.4. ГАМШГААС ХАМГААЛАХ ӨНДӨРЖҮҮЛСЭН БОЛОН БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН
ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ц (Хугацаа) цаг:минут	Хариуцах бүтцийн нэгж	Хамтран ажиллах бүтцийн нэгж, байгууллага
1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ				
1.	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах	Ц+тухай бүр	БЗХАГ, ГШУГ	УОКАА
2.	Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх талаар холбогдох Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн төсөл боловсруулж танилцуулах	Ц+тухай бүр	ГШУГ	БЗХАГ
3.	Албаны хэмжээнд Онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тушаал батлуулах	Ц+тухай бүр	ЗУГ	ГШУГ
4.	ОБЕГ-ын шуурхай штабыг байгуулах тушаалын төсөл боловсруулах, эргүүл, жижүүрийн хуваарь гаргаж батлуулах (24 цагийн үүрэг гүйцэтгүүлэх)	Ц+тухай бүр	ГШУГ	ЗУГ
5.	Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрийн хэрэгжилт, үүрэг чиглэл, удирдлагын харилцан ажиллагааг шуурхай хангах	Ц+тухай бүр	ГШУГ	Бүтцийн нэгжүүд
6.	24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа эргүүл, жижүүрийн бүрэлдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуй хангагдсан байдалд хяналт тавих	Ц+тухай бүр	Шуурхай штаб	ДХШАБГ
7.	Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штабын ажиллах удирдамжийг боловсруулж батлуулах	Ц+тухай бүр	ГШУГ	ЗУГ
8.	Улсын онцгой комиссын шуурхай штабтай цаг үеийн мэдээ, мэдээлэл солилцох, холбогдох шийдвэрийг гаргах.	Ц+тухай бүр	Шуурхай штаб	ГШУГ
9.	Аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабаас мэдээ мэдээллийг тухай бүр хүлээн авах, нэгтгэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах	Ц+тухай бүр	Шуурхай штаб	АНОББ

10.	Аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангах	Ц+тухай бүр	Шуурхай штаб	Бүтцийн нэгжүүд
11.	Аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, хэлтсийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үүрэг чиглэл өгөх	Ц+12:00	Шуурхай штаб	Бүтцийн нэгжүүд
12.	Аймаг, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штаб, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг мэргэжил арга зүйгээр хангах	Ц+тогтмол	Шуурхай штаб	ГШУГ, ГУСГ
13.	Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах шуурхай бүлгийг шаардлагатай тохиолдолд орон нутагт томилж ажиллуулах	Ц+тухай бүр	ГШУГ	ЗУГ, СХХОГ
14.	Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтэдийн зөвлөлд алба хаагчийг томилон ажиллуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах	Ц+тухай бүр	ГСХ	
15.	Цар тахалтай тэмцэх чиглэлээр гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулж буй уулзалт, хурал, семинар, сургалтад алба хаагчдыг цахимаар оролцуулах	Ц+тухай бүр	БЗХАГ	Бүтцийн нэгжүүд, Холбогдох байгууллагууд
16.	Улсын онцгой комиссын ажлын алба болон шуурхай штабт шаардлагатай мэргэжилтнийг томилон ажиллуулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	ЗУГ, ГШУГ	Бүтцийн нэгжүүд
17.	Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа гадаад улс орны туршлагаас судлах, нэвтрүүлэх	Ц+тухай бүр	ГСХ	Бүтцийн нэгжүүд
18.	Шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагаатай улс орон, олон улсын байгууллага, Монгол дахь дипломат төлөөлөгчийн газрыг нөхцөл байдлын мэдээ, мэдээллээр хангах, тэдгээрийн төлөөллийг холбогдох албан тушаалтантай уулзуулах ажлыг зохион байгуулах	Ц+тухай бүр	БЗХАГ	Бүтцийн нэгжүүд, Холбогдох байгууллагууд
19.	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд халдварын эрсдэлийн үнэлгээ хийх	Ц+тухай бүр	ГЭУГ, ГШУГ	Аймгийн ОБГ, ЭМТ

20.	Онцгой байдлын ерөнхий газрын ажилтан, алба хаагчдын шаардлагатай судалгааг гаргах, тусгай цагийн хуваарьт шилжүүлж үүрэг гүйцэтгүүлэх	Ц+тухай бүр	ЗУГ	Бүтцийн нэгжүүд
21.	Бие бүрэлдэхүүний бүртгэл судалгааг нарийвчлан гаргах, амралт, чөлөөгөөр явсан алба хаагчидтай холбоо тогтоох, бэлэн байдлыг хангах	Ц+тухай бүр	Шуурхай штаб	ЗУГ
22.	Онцгой байдлын ерөнхий газрын төв байрны дотоод аюулгүй байдлыг хангах	Ц+тухай бүр	ЗУГ, ДХШАБГ	Бүтцийн нэгжүүд
23.	Бэлэн байдлыг хангахтай холбогдуулан гарсан удирдлагын тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд цаг тухайд нь хүргэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавина	Ц+тухай бүр	ЗУГ	Бүтцийн нэгжүүд
24.	Монгол Улсын хэмжээнд шинээр батлагдсан өвчлөлийн тохиолдлыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын ажлын зурагт оруулж тухай бүр тодотгох, удирдлагыг мэдээллээр хангах	Ц+24:00	Шуурхай штаб	ГШУГ
25.	Засгийн газар, Улсын онцгой комиссын холбогдох шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээнд хяналт, дүн шинжилгээ хийх, удирдлагад танилцуулах	Ц+тухай бүр	ДХШАБГ	Шуурхай штаб
26.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гамшгийн үед харилцан ажиллах төлөвлөгөө, дайчилгааны төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд, тодотгол хийх	Ц+тухай бүр	ГШУГ	БЗХАГ
2. ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛТГЭЛ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ				
1.	Онцгой байдлын ерөнхий газрын алба хаагчдыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх PCR болон түргэвчилсэн шинжилгээнд хамруулах	Ц+тухай бүр	ГШУГ	Бүтцийн нэгжүүд ХӨСҮТ
2.	Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн бие бүрэлдэхүүнийг халдвараас урьдчилан сэргийлэх PCR түргэвчилсэн шинжилгээ, оношилгоонд хамруулах	Ц+тухай бүр	АНОБГ	-

3.	Иргэд олон нийтэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, тараах материалыг хэвлэх, байгууллагын цахим хуудсанд байршуулах.	Ц+тухай бүр	ГУСГ	ГШУГ
4.	Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх шторк бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээх.	Ц+24:00	ГУСГ	АНОБГ
5.	Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Шуурхай штаб болон мэргэжлийн байгууллагуудаас гарсан, тогтоол, тушаал, удирдамжийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэдэд хүргэх.	Ц+тухай бүр	ГУСГ	Шуурхай штаб
6.	Онцгой байдлын байгууллагаас голомтын бүсэд ажиллах алба хаагчдыг хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, тайлах дарааллыг сургаж, дадлагажуулах.	Ц+тухай бүр	ГШУГ	ГУСГ, ХӨСҮТ
7.	Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагтай цахим хурлыг зохион байгуулах, техникийн бэлэн байдлыг хангах,	Ц+тухай бүр	ГШУГ	Шуурхай штаб
8.	Гамшгийн аюулын тухай мэдээллийг дамжуулах Зарлан мэдээллийн цамхагын бэлэн байдлыг хангах, үзлэг шалгалт хийх	Ц+12:00	ШУЗМТ	ГШУГ
9.	Коронавируст халдвар, хамгааллын дэглэмийг сахих, аюулгүй байдлыг хангах талаар сэрэмжлүүлэх мэдээг зарлан мэдээллийн дохиогоор өдөрт 4-5 удаагийн давтамжтай хүргэх	Ц+тогтмол	ШУЗМТ	ГШУГ, ГУСГ
10.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед ОБЕГ-ын ажиллах төлөвлөгөөний хүч хэрэгслийг тодотгох, бэлэн байдлыг хангах	Ц+12:00	ГШУГ	АНОБГ
11.	Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын хүч хэрэгслийг тодотгох, бэлэн байдлыг хангах	Ц+24:00	АНОБГ	
12.	Бие бүрэлдэхүүний хаяг, байршил, холбооны бэлтгэл бэлэн байдлыг тодотгох, шаардлагатай тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэх	Ц+24:00	ГШУГ, ШУЗМТ	Бүтцийн нэгжүүд
13.	Томилгоот бие бүрэлдэхүүн, техник, багаж зэвсэглэмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, удирдлагаар хангах	Ц+12:00	ГШУГ, ГТТГ, ҮАБ	Бүтцийн нэгжүүд
14.	Албаны болон алба хаагчдын хувийн тээврийн хэрэгслийн судалгааг гаргах, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөн	Ц+12:00	ЗУГ	ҮАБ

	үйлдэх тусгай зөвшөөрөл (QR) авах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах			
15.	Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай штаб, жижүүрийн бүрэлдэхүүнийг чанар сайтай хоол хүнсээр хангах	Ц+24:00	ДССЗТ	Бүтцийн нэгжүүд
16.	Тусгаарлах байрны Галын аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах	Ц+24:00	ГТТГ	Холбогдох ажлын хэсэг
17.	Тусгаарлан ажиглах байрны дотоод хөдөлгөөн, хөл хорионы дэглэмийг камераар хяналт тавих алба хаагчдыг заавар, зөвлөмжөөр хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Ц+тогтмол	ГШУГ	ҮАБ, ААНБ
18.	Авто замын шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгт алба хаагчдыг томилгоожуулан үүрэг гүйцэтгүүлэх, бэлэн байдлыг хангах	Ц+24:00	АНОБГ	Холбогдох байгууллагууд
19.	Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд урьдчилан сэргийлэх, хяналт-эргүүл ажиллуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Ц+тухай бүр	ГШУГ	Бүтцийн нэгжүүд
20.	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт явуулах удирдамж боловсруулж батлуулах, томоохон зах, худалдааны төв, эмийн сан, бөөний төвүүдэд хяналт шалгалтыг явуулах	Ц+тухай бүр	ГШУГ, ГТТГ	ШӨХТГ
3. ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ, ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТАЛААР				
1.	Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэмийн цар хүрээг тогтооход дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	Ц+тухай бүр	ГШУГ	АНОБГ
2.	Шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгээр орох, гарах хөдөлгөөний хязгаарлалтад хяналт тавих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	ГШУГ	АНОБГ
3.	Батлагдсан тохиолдлын хавьтлын тандалт судалгаа хийх, эрэн хайх, хаяг байршлыг олж тогтооход холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	ГШУГ	АНОБГ

4.	Аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн хөдөлгөөнд тэг зогсолт хийх, хязгаарлалт тогтоох, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	Шуурхай штаб	АНОБГ
5.	Голомтын бүс, тусгаарлан ажиглах байрны харуул хамгаалалт, гэрийн тусгаарлалтын хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	ГШУГ	ҮАБ, АНОБГ
6.	Улс, хот хоорондын авто тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх	Ц+тухай бүр	АНОБГ	Холбогдох байгууллагууд
7.	Лабораторид суурилсан тандалт оношилгооны цэгүүдэд Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг томилон үүрэг гүйцэтгүүлэх	Ц+тухай бүр	ГШУГ	АНОБГ
8.	Онцгой байдлын ерөнхий газрын төв байр болон Гамшиг судлалын хүрээлэнгийн байранд ариутгал, халдваргүйтгэл хийх	Ц+тухай бүр	ГШУГ	Аж ахуй нэгж
9.	Шаардлагатай үед Хээрийн II шатны эмнэлгийг дэлгэх, бэлэн байдлыг хангах	Ц+тухай бүр	ГШУГ	ЗХЖШ, ХӨСҮТ,
4. САНХҮҮ, ХАНГАЛТ, НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ				
1.	Гадаад орноос ирсэн Монгол Улсын иргэдийг тусгаарлах байрны гэрээг хийх, зардлын тооцоог хийх, олгох	Ц+тухай бүр	СХХОГ	УОК-ын ШШ, ААНБ
2.	Шуурхай штаб, шуурхай бүлэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шаардлагатай техник хэрэгсэл, хүнс, шатах тослох материалаар хангах.	Ц+тухай бүр	СХХОГ	ҮАБ
3.	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд Шуурхай штабын байранд бичиг хэрэг, шаардлагатай үед эм, эмийн хэрэглээгээр хангах	Ц+тухай бүр	СХХОГ	ДССЗТ
4.	Шаардлагатай тохиолдолд байгууллагын нөөцөд байгаа техник, багаж, хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хүнс, шатах тослох материалыг Шуурхай штаб, Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнд олгох.	Ц+тухай бүр	СХХОГ	ҮАБ

5.	Цар тахалтай тэмцэх үед шаардлагатай нэмэлт санхүүжилтийн тооцоог гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Ц+тухай бүр	СХХОГ	АНОБГ
6.	Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын томилолт, урамшууллын зардлын тооцоог гаргах, холбогдох газарт танилцуулах шийдвэрлүүлэх,	Ц+тухай бүр	СХХОГ	АНОБГ
7.	Голомтын бүсэд томилогдон үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг халдвар хамгааллын хувцас, хэрэгслээр хангах	Ц+тухай бүр	СХХОГ	УНХТГ, АНОБГ
8.	Алба хаагчдын дархлааг дэмжих эм, тариа, гар ариутгах бодис, амны хаалт /маск/-аар хангах, нөөц бүрдүүлэх	Ц+тухай бүр	УНХТГ	СХХОГ, АНОБГ
9.	Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэх бодисын хангалтыг зохион байгуулах, нөөцийг бүрдүүлэх	Ц+тухай бүр	УНХТГ	УОК, ОУБ, АОБГ
10.	Дотоодын хандив тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах	Ц+тухай бүр	УНХТГ	УОК, АНОБГ, ААНБ
11.	Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэх, олгох ажлыг зохион байгуулах	Ц+тухай бүр	УНХТГ	УОК, ОУБ, АНОБГ
12.	Улсын нөөцийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг аймаг, нийслэл, сум, дүүргээр тодотгох	Ц+24:00	УНХТГ	ХХААЯ, АНОБГ,
13.	Бие даан үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлгийн өвөл, зуны хөдөлгөөнт байрыг бэлтгэх, хангах, бэлэн байлгах.	Ц+тухай бүр	АНОБГ	ҮАБ
14.	Хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад заасны дагуу бэлтгэх.	Ц+тухай бүр	ГШУГ	Бүтцийн нэгжүүд
15.	Байгууллагын нууцлалыг хадгалах, хуульд заасны дагуу хэрэгжүүлэх	Ц+00:00	ЗУГ	Бүтцийн нэгжүүд

----- o0o -----